



“ХҮҮХЭД, ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ 2018 ОНЫ ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА” ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

Үндэслэл: Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Гэр бүлийн өдрийг тэмдэглэх тухай” 08 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.5.9 дэх заалтаар Үйлчилгээний байгууллагууд /худалдааны төв, зоогийн газар, галт тэрэг, онгоцны буудал, банк, үзвэр үйлчилгээний газар/-д хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг нэвтрүүлнэ. Хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх санал санаачлагыг өрнүүлж, “Хүүхэд, гэр бүлд ээлтэй” байгууллага, үйлчилгээ, орчныг шалгаруулан, олон нийтэд сурталчилна заалтын хүрээнд Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлнэ.

Зорилго: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг үйлчилгээний байгууллагуудыг хүүхэд, гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр уриалах, санал санаачлагыг дэвшүүлэх, тэдний үйл ажиллагааг дэмжих, нийгмийн хариуцлага, ухамсрыг дээшлүүлэхэд оршино.

Зохион байгуулагч:

- Нийслэлийн Засаг Даргын Тамгын газар
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
- Нийслэлийн хүүхэд, Гэр бүлийн хөгжлийн газар
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар

Хугацаа: 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 11-дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл

Хамрах хүрээ: Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, сургууль, цэцэрлэг, ресторан зоогийн газар, худалдааны төв, галт тэрэг, онгоцны буудал, банк, үзвэр үйлчилгээний газар хамрагдана.

Шалгаруулах номинациуд:

1. Хүүхэд, гэр бүлд ээлтэй дүүрэг
2. Хүүхэд, гэр бүлд ээлтэй хороо
3. Хүүхэд, гэр бүлд ээлтэй сургууль
4. Хүүхэд гэр бүлд ээлтэй цэцэрлэг
5. Хүүхэд, гэр бүлд ээлтэй олон улсын, төрийн бус байгууллага байгууллага
6. Хүүхэд, гэр бүлд ээлтэй галт тэрэг, онгоцны буудал, банк, үзвэр үйлчилгээний байгууллага
7. Хүүхэд, гэр бүлд ээлтэй ресторан зоогийн газар, худалдаа үйлчилгээний байгууллага /5 хүртэл/
8. Хүүхэд, гэр бүлд ээлтэй үйлдвэр

Зохион байгуулалт:

Материал хүлээн авах

- Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс байгууллагуудаас ирүүлсэн шаардлага хангасан тайлан, материалыг 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүлээн авна.
- Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс нь Нийслэлийн Хүүхэд гэр бүлийн хөгжлийн газарт 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдөр “2018 оны Нийслэлийн Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага”-д нэр дэвшсэн байгууллагуудын материалыг ирүүлнэ.

Сонгон шалгаруулалт

- Дүүргийн ажлын хэсэг нь “2018 оны Нийслэлийн Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага”-ыг 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 22-ны өдрийг хүртэлх хугацаанд сонгон шалгаруулсан байна.
- Нийслэлийн ажлын хэсэг нь 2018 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 10-ны өдрүүдэд нэр дэвшигч байгууллагуудын материал, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаатай танилцаж, саналаа ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, шалгаруулна.

Нэр дэвшигчид тавигдах шалгуур үзүүлэлтүүд:

Номинациуд	Шалгуур, үзүүлэлт
1. Хүүхдэд ээлтэй дүүрэг	<ul style="list-style-type: none">- Хүүхдийн төлөө зөвлөлийн хуралдсан тоо, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр, хэрэгжилтийн чанар, үр дүн- Дүүргийн гэр бүл, хүүхэд рүү чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж гаргасан шийдвэрийн тоо, олгосон санхүүжилт- Зорилтот бүлгийн хүүхэд, тэдний гэр бүлд чиглэн гаргасан бодлого, шийдвэрийн тоо, хэрэгжилтийн хувь, чанар, үр дүн- Хүүхдээс ирсэн өргөдөл гомдлын тоо, шийдвэрлэлтийн хувь, чанар, үр дүн- Шийдвэр гаргах үйл ажиллагаанд хүүхдийн саналыг сонсож, тусгасан байдал- Хүүхэд, гэр бүл, залуучуудын чиглэлээрх төрийн бус, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажилласан байдал- Хүүхэд, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр хийсэн бүтээн байгуулалт, санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ, үр дүн- ЕБС, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил /сургууль, цэцэрлэгийг шинээр барих, өргөтгөх, гэр цэцэрлэг, аж ахуй нэгж байгууллагын дэргэдэх цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо- Гэмт хэрэг, зам тээврийн осол гэмтэлд хүүхэд, гэр бүлийг өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хийсэн ажлууд /гэрэлтүүлэг, камержуулалт, замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч, иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа г.м/
2. Хүүхэд гэр бүлд ээлтэй хороо	<ul style="list-style-type: none">- Хорооны нийт хүн амыг хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээрх үйл ажиллагаанд хамруулсан байдал- Амьжиргааны баталгаажих түвшинээс доогуур орлогтой хүүхдийн тоо – зуслан, хөгжлийн үйлчилгээнд хамруулсан

	<p>хүүхдийн тоо</p> <ul style="list-style-type: none"> - Халамжийн хүнсний талон авдаг нийт өрхийн тоо- халамжийн үйлчилгээнээс хасагдсан өрхийн тоо - Хорооны нийт 0-2 насны хүүхдийн тоо -2018 онд эх, хүүхдэд үзүүлсэн өрхийн эмнэлгийн үйлчилгээний төрөл, чанар - Хорооны нутаг дэвсгэрт хүүхэд гэр бүлд зориулан 2018 онд шинээр хийгдсэн бүтээн байгуулалт, тохижилт, үйлчилгээ - Хорооны хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг зөрчлийн тоо-2018 онд шийдвэрлэсэн хэргийн тоо
<p>3.Хүүхэд гэр бүлд ээлтэй сургууль</p>	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн ажилтанд хүүхдээс хандан ирүүлсэн хүсэлт-шийдвэрлэлтийн хувь - Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр зохион байгуулсан сургалт, сурталчилгааны ажлын тоо – хамрагдсан хувь /эцэг эх, хүүхэд, багш, ажилтан албан хаагчид/ - ХӨУБ-аас санаачлан хийж хэрэгжүүлсэн ажил-хамтрагдалтын хувь - Сургуулийн захиргаанаас ХӨУБ-ыг үйл ажиллагааг дэмжиж гаргасан шийдвэрийн тоо - Дугуйлан секцийн төрөл, тоо-хамрагдсан хүүхдийн тоо, үзүүлсэн амжилт - Хамран сургах тойргын нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо- сургуульд хамрагдсан хувь - Сургууль гадаад болон дотоод орчныг ээлтэй болгох чиглэлээр өөрийн нөөц боломжид тулгуурлан хийсэн үйл ажиллагаа, тохижилт /ариун цэврийн өрөө, анги танхим тохижилт, гэрэлтүүлэг, замын тэмдэг, тэмдэглэгээ, камержуулалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэд бүтэц, хог тээвэрлэлт, үдийн цай хөтөлбөр болон сургуулийн цайны газрын эрүүл аюулгүй байдал/ - Сургуулийн орчинд ус цэвэршүүлэгч болон гар ариутгах боломж бүрдүүлсэн байдал - School police- ийн үйл ажиллагааны тайлан - Сургуулийн орчинд үйлчилгээ үзүүлдэг байгууллага байгаа эсэх- тэдэнд хандан хийсэн үйл ажиллагааны тайлан - Нийгмийн ажилтанд бүртгэгдсэн кейсийн тоо- ажиллаж хаасан байдал - Сургуулийн эмч, сэтгэл зүйчийн ажлын харьцуулсан тоон үзүүлэлтийн тайлан - Нийт эцэг эхийн 30%-иас авсан сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлт, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн байдал - Хүүхдүүдэд эрүүл амьдрах дадал хэвшил олгох сургалт сурталчилгааны ажлууд /хог ангилан ялгах, гараа угаах дадал, замын хөдөлгөөнд оролцох соёл, харилцааны соёл, олон нийтийн дунд биеэ авч явах гэх мэт/
<p>4. Хүүхдэд ээлтэй цэцэрлэг</p>	<ul style="list-style-type: none"> - Арга зүйчид хүүхэд, тэдний ар гэрээс хандан ирүүлсэн хүсэлт- шийдвэрлэлтийн хувь - Хүүхдийн эрх, хамгааллын /хүүхдийн эерэг арга/ чиглэлээр зохион байгуулсан сургалт, сурталчилгааны ажлын тоо,төрөл, чанар, үр дүн – хамрагдсан хувь /эцэг эх,

	<ul style="list-style-type: none"> - хүүхэд, багш, ажилтан албан хаагчид/ - Бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг хангаж ажилласан талаарх харьяа дүүргийн Боловсролын хэлтсийн албан тоот - Хамран сургах тойргын нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо- цэцэрлэгт хамрагдсан хувь - Цэцэрлэгийн гадаад болон дотоод орчныг ээлтэй болгох чиглэлээр өөрийн нөөц боломжид тулгуурлан хийсэн үйл ажиллагаа, тохижилт /ариун цэврийн өрөө, анги танхим тохижилт, гэрэлтүүлэг, замын тэмдэг, тэмдэглэгээ, камержуулалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дэд бүтэц/ - Цэцэрлэгийн орчинд үйлчилгээ үзүүлдэг байгууллага байгаа эсэх- тэдэнд хандан хийсэн үйл ажиллагааны тайлан - Цэцэрлэг дэх хүүхэд хамгааллын чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан - Хүүхэд багачуудад эрүүл амьдрах дадал хэвшил олгох сургалт сурталчилгааны ажлууд /хог ангилан ялгах, гараа угаах дадал, замын хөдөлгөөнд оролцох соёл, харилцааны соёл, олон нийтийн дунд биеэ авч явах гэх мэт/ - Цэцэрлэгийн орчинд ус цэвэршүүлэгч болон гар ариутгах боломж бүрдүүлсэн байдал - Цэцэрлэгийн эмчийн ажлын харьцуулсан тоон үзүүлэлтийн тайлан - Нийт эцэг эхийн 30%-иас авсан сэтгэл ханамжийн судалгааны үзүүлэлт, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсэн байдал
<p>5. Хүүхэд, гэр бүлд ээлтэй олон улсын, төрийн бус байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Тухайн онд Хүүхэд, гэр бүлд чиглэн хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны тоо, төрөл, төсөв, хамрагдалтын хувь, үр дүн - Хүүхэд, гэр бүлд чиглэсэн хөрөнгө оруулалтын зориулалт, хэмжээ, биелэлтийн хувь, үр дүн - Хүүхэд, гэр бүлийн асуудлаар боловсруулан гаргасан гарын авлага, арга зүй, ном товхимол - Хүүхэд, гэр бүлийн асуудлаар хийсэн судалгаа, шинжилгээний ажил - Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр хийсэн нөлөөллийн ажлын тоо, төрөл, гарсан үр дүн - Үйл ажиллагаанд хамрагдсан хүүхэд, гэр бүлээс авсан сэтгэл ханамжийн судалгааны үнэлгээ - Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн байгууллагатай хамтран ажилласан байдал - Хүүхэд, гэр бүлийн чиглэлээрх төрийн бодлого, шийдвэр, үйлчилгээний чанарыг сайжруулахтай холбогдуулан оруулсан санал, илгээсэн хүсэлт, гарсан үр дүн
<p>6. Хүүхэд, гэр бүлд</p>	<ul style="list-style-type: none"> - Тоглолт, үзвэр үйлчилгээ, зохион байгуулж буй үйл

<p>ээлтэй, галт тэрэг, онгоцны буудал, банк, үзвэр үйлчилгээний байгууллага</p>	<p>ажиллагаандаа хүүхэд, гэр бүлд зориулсан хөнгөлөлт урамшуулал бий болгосон байдал</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд, гэр бүлд таатай, ээлтэй орчинг бүрдүүлэх, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон үйлчилгээг бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, тохижилт, үйлчилгээний ажил, үр дүн /хүүхэд түр саатуулах газар, хүүхдийн ариун цэврийн өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохижилт, жирэмсэн эх, өндөр настанд зориулсан үйлчилгээ, тохижилт/ - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэр дундаа харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээг нэвтрүүлсэн байдал - Хүүхэд, гэр бүлд зориулан шинээр бүтээсэн уран бүтээл - Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал - Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа - Иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгаа, судалгааны үр дүнг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байдал
<p>7.Хүүхэд, гэр бүлд ээлтэй ресторан зоогийн газар, худалдаа үйлчилгээний байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хүүхэд гэр бүлд харшлахгүй, сөрөг нөлөөгүй байх, - Хүүхэд гэр бүлд чиглэсэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөнгөлөлт урамшууллыг бий болгосон байдал - Хүүхэд, гэр бүлд таатай, ээлтэй орчинг бүрдүүлэх, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон үйлчилгээ, бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, тохижилт, үйлчилгээний ажил, үр дүн - /хүүхэд түр саатуулах булан, тоглоомын талбай, хүүхдэд зориулсан ширээ, сандал, хүүхдийн ариун цэврийн өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохижилт/ - Иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгаа, судалгааны үр дүнг үйл ажиллагаа, бүтээгдэхүүндээ нэвтрүүлсэн байдал - Бага насны хүүхдийн бие физиологийн онцлогт тохирсон хоолны жор технологийг баталж мөрддөг байх
<p>8.Хүүхэд, гэр бүлд ээлтэй үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага</p>	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үзүүлж буй үйлчилгээний хувьд хүүхэд гэр бүлд харшлахгүй, сөрөг нөлөөгүй байх - Хүүхэд гэр бүлд чиглэсэн шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөнгөлөлт урамшууллыг бий болгосон байдал - Хүүхэд, гэр бүлд таатай, ээлтэй орчинг бүрдүүлэх, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон үйлчилгээ, бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, тохижилт, үйлчилгээний ажил, үр дүн /хүүхэд түр саатуулах газар, хүүхдийн ариун цэврийн өрөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохижилт, жирэмсэн эх, өндөр настанд зориулсан үйлчилгээ, тохижилт/ - Иргэдээс авсан сэтгэл ханамжийн судалгаа, судалгааны үр

	<p>дүнг үйл ажиллагаа, бүтээгдэхүүндээ нэвтрүүлсэн байдал</p> <ul style="list-style-type: none">- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэр дундаа харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээнэвтрүүлсэн байдал- Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал- Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа
--	---

Шагнал урамшуулал: Шалгарсан байгууллагуудыг тухайн жилийн “ Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага”-аар өргөмжилж хүндэт өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна.